

САНАЛЫН ТОВЪЁОГ

“Чөлөөт бүсэд мөрдөх журам”-ын төсөлд холбогдох мэргэжлийн байгууллагуудад “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/66 дугаар албан бичгийг Хил хамгаалах ерөнхий газарт, 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/68 дугаар албан бичгийг Гаалийн ерөнхий газарт, 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/69 дүгээр албан бичгийг Татварын ерөнхий газарт, 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/70 дугаар албан бичгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт тус тус хүргүүлж, журмын төсөлд бичгээр санал авах ажиллагааг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хооронд зохион байгуулсан.

Дээрхи ажлын хүрээнд дараах саналуудыг ирүүлсэн байна.

№	Байгууллагын нэр	Дэмжсэн эсэх	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх	Тайлбар
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Дэмжсэн	1.Төслийн 2.2.1 дэх заалтын “Монгол Улсын иргэн гадаад паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх;” гэснийг “Монгол Улсын иргэн үндэсний гадаад паспорт, иргэний үнэмлэх, түүнийг орлох бичиг баримт, жолооны үнэмлэх” гэж өөрчлөн найруулах	Саналын дагуу “гадаад паспорт” гэсний өмнө “Үндэсний” гэж нэмсэн.”	Харин “иргэний үнэмлэхийг орлох бичиг баримт” гэсэн ойлголт нь Чөлөөт бүсийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх заалтад байхгүй бөгөөд Иргэний үнэмлэхийг орлох баримт бичиг байхгүй тул хуульд нийцүүлэх үүднээс төсөлд тусгаагүй болно.
			2.Төслийн 2.2.3 дахь заалтын “Монгол Улсын 16 насанд хүрээгүй иргэн төрсний гэрчилгээ, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг.” гэснийг “Монгол Улсын 16 насанд хүрээгүй иргэн төрсний гэрчилгээ, үндэсний гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримт” гэж өөрчлөн найруулах.	Саналыг “Монгол Улсын 16 насанд хүрээгүй иргэн төрсний гэрчилгээ, үндэсний гадаад паспорт” гэж өөрчлөн найруулж төсөлд тусгасан.	Гадаа паспортыг орлох баримт бичиг буюу буцах үнэмлэх нь гадаад улсаас эх орондоо ирж байгаа тохиолдолд нэг удаа хэрэглэгддэг бичиг баримт учраас чөлөөт бүсэд зорчиж байгаа тохиолдолд шаардлагагүй гэж үзсэн.
			3.Төслийн 3.4.1 дэх заалтын “иргэний үнэмлэх болон гадаад	Саналыг “Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, хил	Чөлөөт бүсэд зорчигдын тухайд “гадаад паспортыг орлох бичиг баримт” гэдэгт

		паспорт;" гэснийг "Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримт" гэж өөрчлөн найруулах.	орчим зорчих үнэмлэх" гэж өөрчлөн найруулж төсөлд тусгасан.	буцах үнэмлэх бус хил орчмын зорчих үнэмлэх багтдаг тул нэмж тусгасан.
		4.Төслийн 6.1.1.4 дэх заалтын "Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгосон хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар;" гэснийг "Улсын бүртгэлийн байгууллагаас олгосон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар" гэж өөрчлөн найруулах.	Саналын дагуу "хуулийн этгээдийн" гэсний дараа "улсын" гэж нэмж төсөлд тусгав.	-
		5.Төслийн 6.4 дэх хэсгийн "Хуулийн этгээдийн бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чөлөөт бүсээс олгосон бүртгэлийн гэрчилгээг үндэслэж хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт оруулна." гэснийг "Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь чөлөөт бүсээс олгосон бүртгэлийн гэрчилгээг үндэслэж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт оруулна." гэж өөрчлөн найруулах.	Саналын дагуу "хуулийн этгээдийн" гэсний дараа "улсын" гэж нэмж төсөлд тусгав.	-
		6.Төслийн 6.5 дахь хэсгийн "Чөлөөт бүсийн бүртгэлийн гэрчилгээ авсан хуулийн этгээд нь хуулийн этгээдийн гэрчилгээнд тухайн чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн бүртгэлийг	Саналын дагуу "хуулийн этгээдийн" гэсний дараа "улсын" гэж нэмж төсөлд тусгав.	-

			Улсын бүртгэлийн газарт хуулийн этгээдийн гэрчилгээнд хийлгэж хуулбарыг ажлын 7 хоногт Захирагчийн ажлын албанд ирүүлнэ.” гэснийг “Чөлөөт бүсийн бүртгэлийн гэрчилгээ авсан хуулийн этгээд нь тухайн чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн бүртгэлийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ажлын 7 хоногт Захирагчийн ажлын албанд ирүүлнэ.” гэж өөрчлөн найруулах.		
2	Хил хамгаалах ерөнхий газар	Чөлөөт бүсийн тухай хуульд заасан агуулгатай нийцэхгүй, холбогдох хуулиар зохицуулагүй санал ирүүлсэн.	1.Чөлөөт бүсэд мөрдөх журам”-ын төсөл нь хилийн зурваст байрлах чөлөөт бүсийн үйл ажиллагаанд хэт чиглэсэн агуулгатай байна. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 29.4-т заасны дагуу Хилийн боомтын үндэсний зөвлөл нь “Хилийн боомтод мөрдөх журам” –ыг, хилийн боомтын зөвлөлийн дарга нь тухайн нийтлэг журам, боомтын онцлогт нийцүүлэн “Хилийн боомтод мөрдөх журам”-ыг тус тус баталж, хэрэгжүүлдэг. Дээрхи агуулга зарчимд тулгуурлан “Чөлөөт бүсэд мөрдөх нийтлэг журам”-ын төслийг дахин боловсруулах нь зүйтэй хэмээн үзэж байгааг уламжилж байна.	-	Чөлөөт бүс нь боомтын үйл ажиллагаанаас тусдаа ойлголт бөгөөд эдгээрийг хооронд нь адилтгаж авч үзэх боломжгүй юм. Учир нь хилийн боомт нь тухайлан нарийвчлан зохицуулсан хууль байхгүй /Боомтын тухай хууль хүчингүй болсон/ бөгөөд хилийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах тус тусын хуулиар зохицуулагддаг онцлогтой. Чөлөөт бүсийн тухай хуулиар үйл ажиллагаанд мөрдөх тусгай дэглэмийг тогтоосон бөгөөд чөлөөт бүсэд мөрдөх дүрэм журмыг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлэхээр хуульчилсан. Мөн чөлөөт

					бүсийг хилийн зурваст болон Засгийн газрын санал болгосон газарт буюу нутгийн гүнд байгуулж болдог онцлогтой. Иймд Чөлөөт бүсийн тухай хуульд заасны дагуу энэхүү нийтлэг журмыг батлан чөлөөт бүсүүдэд мөрдүүлэх нь төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй, нэг цонхоор үзүүлэх чөлөөт бүсийн суурь зарчимд нийцэх тул саналыг хүлээж авах боломжгүй болно.
3	Татварын ерөнхий газар	Дэмжсэн	1.Төслийн 2.3, 2.4, 10.3 дахь хэсгийн “хил, гааль” гэсний дараа “татвар” гэж нэмэх.	Саналыг тусгасан.	-
			2.Төслийн 8.4.3-т “.....Засгийн газрын шийдвэрийн дагуу зохицуулна.” гэсэн нь “Засгийн газрын шийдвэр гэж юуг хэлж байгаа эсэх, эрх олгосон хуулийн заалт байгаа эсэх	-	Татвар, төлбөр хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой зохицуулалтыг Чөлөөт бүсийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт Засгийн газар шийдвэрлэж байхаар хуульчилсан.
			3.Төслийн 8 дугаар зүйлд “чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний	Саналыг тусгасан.	Хэдийгээр энэхүү хөнгөлөлт, чөлөөлөлт нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу хуулийн заалтыг давхардуулан журамд тусгахгүй байхаар

		хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.7-д заасны дагуу татварын зохих хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ.” гэсэн 8.4.4 дэх заалт нэмэх.		төсөлд тусгаагүй байсан боловч Мэргэжлийн байгууллын саналыг харгалзан төсөлд нэмж тусгав.
		4.Төслийн 8 дугаар зүйлд “чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.8-д заасны дагуу татварын зохих хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ.” гэсэн 8.4.5 дахь заалт нэмэх.	Саналыг тусгасан.	Мөн адил
		5.Төслийн 8 дугаар зүйлд “чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүд Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Татварын удирдлага, нэгдсэн системд холбогдож төлбөрийн баримт олгох үүрэгтэй бөгөөд олгоогүй тохиолдолд хуульд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрхгүй.” гэсэн 8.4.6 дахь заалт нэмэх.	Саналыг тусгасан.	-

		<p>6.Төслийн 8 дугаар зүйлд “Энэ журмын 8.4.6-д заасан төлбөрийн баримт олгоогүй, шаардлага биелүүлээгүй этгээдэд Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах эрхийг цуцлах” гэсэн 8.4.7 дахь заалт нэмэх.</p>	<p>Саналыг тусгасан.</p>	<p>Зөрчлийн тухай хуультай нийцэж байгаа.</p>
		<p>7.Төслийн 8 дугаар зүйлд “Чөлөөт бүсэд нэвтрүүлж байгаа болон хилийн гарцаар гаргаж байгаа бараанд эрсдэлд суурилсан татварын хяналтыг тавина.” гэсэн 8.4.8 дахь заалт нэмэх.</p>	<p>Саналыг тусгасан.</p>	<p>Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд эрсдэлд суурилсан хяналтыг тавих боломжтой.</p>
		<p>8.Төслийн 8 дугаар зүйлд “Энэ журмын 8.3.5-д дурдсан мэдээллийг тухай бүр татварын албанд хүргүүлнэ.” гэсэн 8.4.9 дэх заалт нэмэх.</p>	<p>Саналыг “Энэ журмын 8.3.5-д дурдсан мэдээллийг гаалийн байгууллага тухай бүр татварын албанд хүргүүлнэ.” гэж нэмж тусгасан.</p>	<p>Саналд дурдсан мэдээлэл нь гаалийн байгууллагад хамааралтай тул гаалийн байгууллагаас хүргүүлж байхаар нэмж тусгав.</p>
		<p>9.Төслийн 10.2-т Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан чөлөөт бүсэд аялал жуулчлал, төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах, банк, банк бус санхүүгийн байгууллага, түүний салбар нэгж байгуулахтай холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монгол банктай байгуулсан гэрээний дагуу зохицуулна.” гэсэн заалтад төлбөрт таавар, бооцоот</p>	<p>Саналыг цаашид анхаарч ажиллах.</p>	<p>Энэхүү журмаар зохицуулахаар эрх олгоогүй харилцаа тул төсөлд нарийвчилж тусгаагүй болно.</p>

			тоглоомын тусгай хувь хэмжээний татварын зохицуулалтыг анхаарах.		
4	Гаалийн ерөнхий газар	Дэмжсэн	1.Төслийн “Чөлөөт бүсэд мөрдөх журам” гэсэн нэр нь бусад чөлөөт бүсүүдэд мөрдөгдөх мэт буруу ойлгогдохоор байгаа тул “Замын-Үүд” чөлөөт бүсэд мөрдөх журам гэж өөрчлөх.	Төсөлд тусгаагүй.	Энэхүү журам нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа чөлөөт бүсүүдэд нийтлэгээр мөрдүүлэх журам тул нэр /гарчиг/-ийг өөрчлөх шаардлагагүй болно.
			2.Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4571 дугаарт бүртгүүлэн нийтээр дагаж мөрдөж байгаа болно. Иймд тус журмын агуулгатай давхцаж байгаа 1.3, 3.1, 3.2, 3.3, 4.1, 4.2, 4.4, 4.5, 8.3.4, 8.3.7 дугаар заалтуудыг төслөөс хасах.	Саналд дурдсан заалтуудыг төсөлд хэвээр үлдээв.	Эдгээр заалтуудын агуулга нь Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журмын заалтуудтай давхардаж байгаа мэт боловч Чөлөөт бүсийн тухай хуульд зааснаар чөлөөт бүсэд мөрдөх журам дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих нарийвчилсан зохицуулалтад нийцүүлэн энэхүү журамд зайлшгүй тусгах шаардлагатай гэж үзсэн.
			3.Төслийн 2.3 дахь хэсгийг дараах байдлаар найруулах. “Чөлөөт бүсэд нэвтрэх үнэмлэхийг Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас дараах ажилтан, албан тушаалтанд олгоно. <ul style="list-style-type: none"> - Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны албан хаагч - Хөрөнгө оруулагч - Үйлчилгээний ажилчин - Гэрээт ажилчин - Хил хамгаалах байгууллагын албан хаагч 	Санал нь техникийн чанартай бөгөөд энэхүү журмын нийтлэг бүтэц, загвартай уялдуулах шаардлагын үүднээс төсөлд тусгаагүй.	-

			Гаалийн байгууллагын албан хаагч		
			4.Төслийн 2.4 дэх хэсэгт заагдсан "...чөлөөт бүсэд ажиллаж буй хил, гааль зэрэг мэргэжлийн албадын албан хаагчид...." гэсэн хэсгийг "... хил хамгаалах, гаалийн байгууллагын албан хаагчдад..." гэж өөрчлөх.	Саналд дурдсан асуудал нь төсөлд тусгасан мэргэжлийн албад гэдэгт багтаж байгаа тул найруулгын хувьд төсөлд тусгах боломжгүй байна.	-
			5.Төслийн 4.3 дахь хэсэг ойлгомжгүй байгаа тул дахин найруулж холбогдох хэсэгт нь оруулах.	Саналын дагуу Энэхүү төслийн 4.2-т заасан хугацаатай уялдуулан холбогдох Засгийн газрын гишүүд зөвшилцөн хугацааг тогтоох, шаардлагатай бол Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэхээр найруулсан.	Энэ асуудал нь чөлөөт бүсийн үйл ажиллагааны явцад татвараас зайлсхийх замаар эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй талаар Улсын Их Хурлын гишүүдээс удаа дараа анхааруулж байгаа тул цаашид шат дараалан зохих зохицуулалт хийх боломжтой байхаар тусгасан.
			6.Төслийн Дөрөв. Чөлөөт бүсээс барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах бүлгийг хасаж, гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбогдох заалтуудыг төслийн "Гурав. Чөлөөт бүсэд бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх" гэсэн бүлэгт нэмж тусгах	Саналыг төсөлд тусгаагүй.	Төслийн гуравдугаар зүйл нь чөлөөт бүс буюу гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаа нутаг дэвсгэрээс бараа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх/хилийн гарцаар/ асуудал, дөрөвдүгээр зүйл нь чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт бараа, тээврийн хэрэгсэл оруулж, гаргах/гүний гарцаар/ асуудлыг зохицуулж байгаа тусдаа ойлголтууд учир нэг зүйлд хамруулах боломжгүй.
			7.Төслийн 7.2 дахь хэсэгт "Гаалийн хууль тогтоомжийг жилд хоёр буюу	Саналд дурдсан Зөрчлийн тухай хуулиар	-

		түүнээс дээш удаа зөрчсөн” гэж нэмэх.	зохицуулах асуудал учир төсөлд тусгаагүй.	
		8.Чөлөөт бүсийн холбогдох хууль тогтоомжид “чөлөөт бүсийн хилийн болон гүний гарц” гэсэн ойлголт тусгагдаагүй бөгөөд чөлөөт бүсэд бараа оруулах, гаргах, боловсруулалт хийх үйл ажиллагаа бүхэлдээ гаалийн байгууллагын хяналтад байх тул төслийн 8.3.1, 8.3.2 дахь заалтуудыг хасаж “Чөлөөт бүсэд бараа оруулах, гаргах, боловсруулалт хийх үйл ажиллагаа гаалийн хяналтад байна” гэж найруулах	Саналын дагуу өөрчлөн найруулав.	-
		9.Барааг чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад гаалийн бүрдүүлэлтийн горим сонгож, бүрдүүлэлт хийх тул төслийн 8.3.6 дахь заалтыг “Барааг чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад гаалийн бүрдүүлэлт хийлгэнэ.” гэж засах	Саналыг тусгав.	-
		10.2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн “Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн дагуу хилийн мэргэжлийн хяналтын чиг үүрэг гаалийн байгууллагад шилжсэн тул төслийн 8.6 дахь хэсгийг хасаж, төслийн “Гурав. Чөлөөт бүсэд бараа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх” гэсэн бүлэгт дараах заалтуудыг нэмж тусгах - Чөлөөт бүсийн гарцаар нэвтрүүлж буй зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа	Саналыг тусгаагүй.	Чөлөөт бүс дэх мэргэжлийн хяналтын зохицуулалт нь Чөлөөт бүсийн тухай хуульд заасан тусгай дэглэмүүдийн нэг бөгөөд хилийн мэргэжлийн хяналтын харьяалах байгууллага нь өөрчлөгдсөн боловч чиг үүрэг хэвээр байгаа тул саналд дурдсанаар чөлөөт бүс дэх гаалийн дэглэмтэй хамтатгаж болохгүй юм.

			<p>бараагаар дамжин Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг хүний хөл хориот халдварт өвчин болон мал амьтны олон улсад шуурхай болон тогтмол мэдээлэх халдварт өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэх хяналт хийх, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Чөлөөт бүс дэх бараа, бүтээгдэхүүнд хүнс, химийн гаралтай хордлого, хордлогот халдвар гарсан үед болон байгаль орчны бохирдолтой холбоотой гомдол, мэдээлэл ирсэн нөхцөлд хяналт хийх <p>Чөлөөт бүсэд хүн, малын гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх үед болон хорио цээрийн дэглэм тогтоосон үед хийгдэх ариутгал, халдваргүйжүүлэх үйл ажиллагааны чанарт хяналт тавих</p>		
3	Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	Дэмжсэн	<p>Чөлөөт бүсэд мөрдөх журам, Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журмын төслүүдийг боловсруулахад 3 чөлөөт бүсийн хамтарсан ажлын хэсэгт тус чөлөөт бүсийн Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга И.Хайратбек орж тухай бүрт нь саналаа тусгуулан</p>	-	Холбогдох журмын төслүүдэд саналыг тусгасан. Нэмэлтээр оруулах саналгүй, төслийг дэмжсэн.

		ажилласан. Иймд дээрхи журмын төсөлд нэмж тусгах саналгүй болно.		
--	--	---	--	--

---oOo---